

БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАРЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО

2019 ОН 07 САР 07 ӨДӨР

ДУГААР 01

Улаанбаатар хот

ЗАЛУУ СУДЛААЧДЫН АНХААРАЛД:

“ХҮРЭЛ ТОГООТ-2019” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Монголын Залуу Эрдэмтдийн Холбооны Байгалийн Ухааны Салбарын Залуу Эрдэмтдийн Холбооноос жил бүр БСШУСЯ, ШУА, ШУТС, МЗЭХ-той хамтран байгалийн ухааны салбарын залуу судлаач, багш, эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд зохион явуулдаг “Хүрэлтогоот-2019” эрдэм шинжилгээний хурал 2019 оны 10-р сард ООГХ-ийн харьяа одон орон судлах “Оргил төв”-д болох тул та бүхэн идэвхитэй оролцож бүтээлээ доор дурьдсан хугацаанд багтаан илгээнэ үү.

Уг хуралд илтгэл тавин оролцсон залуу судлаачдыг мэдлэг, чадвар, судалгааны ажлын үр дүнгээр нь шалгаруулан 35 хүртэлх насны, докторын зэрэг хамгаалаагүй хоёр залуу судлаачийг БСШУС-ын сайдын залуу судлаачид олгодог **4 сая төгрөгний ГРАНТ**-д Байгалийн Ухааны Салбараас дэвшүүлнэ.

Энэхүү бага хуралд оролцох бүтээл буюу эрдэм шинжилгээний өгүүллийг бүрэн эхээр нь 2019 оны 9-р сарын 1-нийг дуустал хүлээн авах тул залуу судлаачид өөрсдийн бүтээлийг дараах тусгай форматын дагуу бэлтгэж зохион байгуулах комисст khureltogoot.nature@gmail.com хаягаар илгээнэ үү. Форматын дагуу бэлтгэж ирүүлээгүй өгүүллийг шалгаруулалтанд оролцуулахгүй болно.

Уг хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг мөн дээрхи хаягаар хандаж авна уу.



ДОКТОР Б.АМАРСАНАА

ЖИШЭЭ ӨГҮҮЛЛИЙН НЭР (Arial, 12pt, **Bold**, ТОМ ҮСГЭЭР, мөр голлон)

(12pt өндөртэй хоосон мөр)

Зохиогчдын нэрс (Arial, 12pt, мөр голлон)

(12pt өндөртэй хоосон мөр)

Улсын нэр, Байгууллагын нэр (Arial, 10pt, *Italic*, мөр голлон)

(10pt өндөртэй хоосон мөр)

Зохиогчтой харьцах e-mail хаяг (Arial, 10pt, *Italic*, мөр голлон)

(10pt өндөртэй 3 хоосон мөр)

Хураангуй (Arial, 10pt, **Bold**, Зүүн талд зэрэгцэх)

(10 pt өндөртэй хоосон мөр)

Өгүүлэл бүрийн өмнө хураангуй бичигдэнэ. Хураангуйг Arial фонтоор 10pt үсгийн өндөртэйгээр *Italic* хэлбэрээр бичнэ. Хураангуй нь 15 мөр, 200 үгэнд багтсан байх ёстой.

Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөрүүд хоорондоо 1sp зайтай байна. Мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.

(10pt өндөртэй 2 хоосон мөр)

Түлхүүр үг (Arial, 10pt, **Bold italic**, Зүүн талд зэрэгцэх): Түлхүүр үг нь Arial фонтоор 10pt үсгийн өндөртэйгээр *italic* хэлбэрээр бичигдэнэ. Өгүүлэлд 4-5 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг нь нэр үг, ганц тоон дээр бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.

(10pt өндөртэй 2 хоосон мөр)

Оршил (Arial, 10pt, **Bold**, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй хоосон мөр)

Өгүүллийн оршил хэсэгт авч үзэж байгаа асуудлын мөн чанар, урьд өмнөх судалгааны түвшин, гол онцлогуудыг бичнэ.

(10pt өндөртэй 2 хоосон мөр)

1. Судалгааны материал арга зүй (Arial, 10pt, Эхний үсэг томоор, **Bold**, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй хоосон мөр)

Өгүүллийг зөвхөн Microsoft Word2003 програм буюу түүнээс хойших хувилбар дээр *.DOC буюу *.DOCX өргөтгөлтэй

форматыг ашиглан Arial үсгийн фонтоор 10pt үсгийн өндрийг сонгон бичнэ.

(10pt өндөртэй 2 хоосон мөр)

2. Үр Дүн ба хэлэлцүүлэг (Arial, 10pt, Эхний үсэг томоор, **Bold**, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй хоосон мөр)

Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй. Хүснэгт нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгтийн гарчиг нь Arial фонтоор *Italic* хэлбэрээр 10pt үсгийн өндөртэйгээр мөр голлон бичигдэнэ.

(10pt өндөртэй хоосон мөр)

1.1-р хүснэгт

Хүснэгтийн гарчиг (*Arial, 10pt, Italic, мөр голлох*)

Хүснэгт	
1	
2	

(10pt өндөртэй хоосон мөр)

Хүрээ шугам нь 0.5 pt өргөнтэй дан шулуунаар байна.

Бүх математик бичлэгүүд MS Equation, MathType, LaTeX програмаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 10pt өндөртэй байна. Томьёо нь дээд, доод талаасаа 10pt зайтай байх ба мөр голлон бичигдэнэ.

(10pt өндөртэй хоосон мөр)

$$s_a = \frac{s_x + s_y}{2} + \frac{s_x - s_y}{2} \cos 2\alpha - t_{xy} \sin 2\alpha$$

(10pt өндөртэй хоосон мөр)

$$U = \frac{1}{2E} (s_1^2 + s_2^2 + s_3^2 - 2(s_1 s_2 + s_2 s_3 + s_3 s_1))$$

Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтанд бичнэ.

Фото зураг, зураг, хүснэгт нь зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг нь 300 dpi нягтралшилтайгаар зургийн *.TIF, *.JPG, *.BMP, *.GIF өргөтгөлтэйгээр буулгагдаж текстэн дотор мөр голлон байрласан байна.

(10pt өндөртэй хоосон мөр)


Ашигласан ном, хэвлэл (*Arial, 10pt, Bold, зүүн талдаа зэрэгцэх*)

(10pt өндөртэй хоосон мөр)

Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, зохиолын нэрс, вэб хаягийг тавих ба өгүүлэлд иш татсан дарааллаар нь дугаарлана. Нэрсийг Arial фонтоор 11pt үсгийн өндөртэйгээр дараах хэлбэрээр бичнэ. Хэрэв 3-аас дээш хүний хамтын бүтээлээс ишлэл татсан бол эхний гурван хүний нэрсийг бичнэ.

(10pt өндөртэй хоосон мөр)

- [1] Төмөрбаатар Н., Балжинням Ш., Гөлгөө А. *Материалын эсэргүүцэл*. Улсын хэвлэл. УБ.: 2. – 295х
- [2] Алтанцэцэг Ч., Буяндэлгэр Д. *Монголчуудын өвлийн улиралд голлон өмсдөг хувцасны нэр төрлийн судалгаа*. /ШУТИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.: 1997. №3(29)41...43х.



1-р зураг. Гангийн сунгалтын диаграмм (*Arial, 10pt, Italic, мөр голлох*)
(10pt өндөртэй хоосон мөр)

Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн 10pt үсэгний өндөртэй тэнцүү байх буюу 85%-иас бага байж болохгүй.

(10pt өндөртэй 2 хоосон мөр)

Дүгнэлт (*Arial, 10pt, Bold, зүүн талдаа зэрэгцэх*)

(10pt өндөртэй хоосон мөр)

Тухайн өгүүллийг дүгнэлтийг Arial фонд дээр 10pt үсгийн өндөртэйгээр Regular горимд бичнэ.